



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 7 өдөр

Дугаар 347

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх эрүүл мэндийн тусламж, нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах үйл ажиллагааг өргөжүүлэн сайжруулах зорилгоор “Тэгш дүүрэн” хөтөлбөрийг үнэлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Үнэлгээг 2015 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081217

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 9 сарын 7 өдрийн
34.7 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН НИЙГЭМ, ХАМТ ОЛОНД ТУШИГЛЭН
СЭРГЭЭН ЗАСАХ "ТЭГШ ДҮҮРЭН" ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭ
ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн, Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод
Аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Н.Тунгалаг, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн
мэргэжилтэн

Г.Базархүрэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит
хариуцсан мэргэжилтэн

А.Бархас, Эрүүл мэнд, боловсрол сургалт, сурталчилгааны
бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн

Б.Цогтбаатар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн
Захирал

Б.Нарантуяа, Сэргээн засах үндэсний төвийн захирал
/зөвшилцсөнөөр/

Га.Бурмаа, Сэргээн засах тусламжийн мэргэжлийн салбар
зөвлөлийн гишүүн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
эрүүл мэнд, боловсролын төв комиссын дарга

О.Чимэдсүрэн, Нийгмийн эрүүл мэндийн ерөнхий
мэргэжилтэн

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 9 сарын 7 өдрийн
3.17 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН НИЙГЭМ, ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН
СЭРГЭЭН ЗАСАХ “ТЭГШ ДҮҮРЭН” ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

Улаанбаатар хот

2015.08.27

1. Үндэслэл:

Эрүүл мэндийн сайдын 2011 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм, хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөр батлах тухай” 216 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2013 онд дунд хугацааны үнэлгээ хийгдэж, 2015 онд төгсгөлийн үнэлгээ хийж дуусгавар болж байна.

2. Зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм, хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээ хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмжөөр хангах


3. Үйл ажиллагааны чиглэл

Хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээг дараах чиглэлээр хийнэ.

- Үнэлгээний хүрээнд баримтын судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, уулзалт, ярилцлага хийх, холбогдох байгууллагын үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм, хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилтийг үнэлнэ.
 - Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, хүрсэн түвшинг тооцон шалтгаан, үр дүнд дүгнэлт хийнэ.
 - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан холбогдох Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг дүгнэнэ.
 - Хамтран ажиллах байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа, Ололт амжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг тусгасан тодорхой зөвлөмж боловсруулна.
 - Зарцуулсан санхүүжилт, үр дүнг тооцно.
 - Хөтөлбөрийг үргэлжлүүлэх эсэх талаар санал дэвшүүлнэ
 - Нэмэлт шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна
- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэнд үнэлгээ өгнө. Үйл ажиллагааны тайлантай танилцаж, холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад газар дээр нь хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцана.

4. Хамрах хүрээ:

- Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар
 - Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
 - БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг
 - Өрх, сумын Эрүүл мэндийн төв
 - Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
 - Сэргээн засах үндэсний хөгжлийн төв
 - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
 - АИФО ТББ
- Хамтран ажиллах байгууллага:
- Хүн амын хөгжил, нийгэм хамгааллын яам
 - Боловсрол шинжлэх ухааны яам
 - Хөдөлмөрийн яам



5. Хугацаа: 2015 оны 08-10 дугаар сар

Баримтын судалгааны болон ярилцлагын аргаар үнэлгээ хийнэ.

А. Баримтын судалгаанд дараах материалыг судлана.

- Хууль (монгол улсын яамны эрх зүйн байдлын хууль, эрүүл мэндийн тухай хууль, хөдөлмөрийн хууль, боловсролын тухай, төсвийн тухай хууль)
- Засгийн газрын тогтоол(2013 оны 281 тоот,)
- Тушаал(Эрүүл мэндийн сайдын 2011 оны 216 тоот, хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамны харьяа сэргээн засалт үндэсний төвийн захирлын А/61, 2013 оны 27 тоот тушаалуудын хэрэгжилтэнд үнэлгээ өгнө)
- Журам(Эрүүл мэндийн сайдын 2011 оны 327 тоот)

Б. Ярилцлагын судалгаанд:

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /тохиролцсоноор/
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газрын ерөнхий боловсрол хариуцсан мэргэжилтэн Б.Туяа
- Хөтөлбөрийг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн
- Сэргээн засах үндэсний төвийн захирал Б.Нарантуяа
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны төлөөлөгч

6. Хүрэх үр дүн:

Хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээний дүнгийн тайлан, санал, зөвлөмж гарч, ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулагдсан байна.